

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХӨРӨӨНЫ ТОВХИМОЛ

2024 – 09 САР | ДУГААР 70

## ГАРЧИГ



- 2–3 Бодлогын нийтлэл
- 4 Зохицуулалтын мэдээ
- 5–6 Байр суурь
- 7 Тайлбар зөвлөмж
- 8–9 Тогтвортой санхүүжилт
- 10–11 Компанийн засаглал, комплайнс
- 12–13 Финтек ба регтек
- 14–19 Судлаачийн индэр
- 20–21 Виртуал хөрөнгө гэж юу вэ?
- 22–23 Олон улсын зах зээлийн мэдээ
- 24 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ: ЖИШЭЭ, ЗӨВЛӨМЖ



**ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ  
БАЙДАЛ, КЕЙС  
СУДЛАГДАХУУН**

### Суптекийн чиг хандлага олон улсад

Санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь технологийн тусламжтайгаар хурдацтай өөрчлөгдөж байна. Дэлхийн улс орнууд хяналт шалгалтын үйл ажиллагааны цар хүрээ, үр ашигт байдлыг нэмэгдүүлэхээр төрөл бүрийн технологийн шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсээр байна.

Дэлхий даяар хяналт, шалгалтын технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй улс орнуудын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Кэмбриджийн Их сургуулийн дэргэдэх Суптек лабаас 2023 онд нийт 64 улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудыг хамруулсан суптек нэвтрүүлэлтийн судалгааг гүйцэтгэсэн бөгөөд тэдгээрийн 81 хувь нь ямар нэгэн хэлбэрээр хяналт, шалгалтын технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй гэж хариулсан нь 2022 оныхоос 10 хувиар өссөн үзүүлэлт ажээ. Мөн судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд өндөр хөгжилтэй болон хөгжиж буй улс орнуудын санхүүгийн хяналт, шалгалтын технологийг нэвтрүүлж буй байдал зөрүүтэй байгаа бөгөөд уг зөрүү нь өнгөрсөн жилээс нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал өндөр хөгжилтэй улс орнуудын 79 хувь нь суптекийг нэвтрүүлж буй бол эрчимтэй хөгжиж буй болон хөгжиж буй улсуудын 54 хувь нь суптекийг нэвтрүүлж буй талаар тайлагнасан байна.

Мөн судалгаанд оролцсон байгууллагуудаас суптекийг нэвтрүүлснээр хяналт, шалгалтын үйл ажиллагааг хэрхэн хөнгөвчилж буйг асуухад оролцогчдын 76 хувь нь хяналт, шалгалтын үйл ажиллагааг түргэвчилсэн, 74 хувь нь олон төрлийн өгөгдлийг хяналт, шалгалтын шинжилгээнд ашиглаж эхэлсэн, 63 хувь нь эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох хяналтын самбарыг ашиглаж эхэлсэн, 61 хувь нь бүтэцлэгдээгүй өгөгдлийг үр дүнтэй ашиглаж эхэлсэн, 54 хувь нь эрт илрүүлгийн системийг ашиглаж эхэлсэн гэх зэрэг хариултаудыг өгсөн. Түүнчлэн зохицуулагч байгууллагуудын суптекийг нэвтрүүлэх зорилгыг тодруулахад зохистой хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах, мөнгө угаах эрсдэлийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зэрэг нь хамгийн их хариултыг авсан.



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### АРДЧИЛАЛ

Ардчиллыг янз бүрээр тодорхойлдог бөгөөд тодорхойлолт бүр цаг үетэйгээ хамт өөрчлөгдөн хөгжсөөр ирэв. Ардчилал нь эрх мэдлийг зөв ашиглах, зөрчилдөөнийг зохицуулах тухай асуудал юм. Энэ нь төрийн шийдвэр болон шийдвэр гаргагчдыг олон нийтийн хяналтад байлгах, ийм хяналтыг хэрэгжүүлэхдээ иргэдийн ашиг сонирхлыг хүндэтгэх тэнцвэртэй зарчимд тулгуурлан улс төрийн институци, үйл явцын нэгдлийг хангана гэсэн хэрэг. Улс орон бүрийн улс төрийн институци, практик тухайн орны түүх, соёл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээр тодорхойлогддог учраас ардчилал чухам тийм байх ёстой гэсэн нийтлэг ухагдахуун байдаггүй.



### DEMOCRACY

Definitions of democracy differ and evolve. Democracy is about the use of power and the management of conflict. It requires a set of political institutions and processes based on the principles of popular control over public decisions and decision makers, and equality of respect and voice between citizens in the exercise of that control. There are no blueprints since every country's political institutions and practices are shaped by its history, culture, social and economic factors

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд 11 салбарын 6,370 гаруй зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааг хянаж, зохицуулж байна.

Үүнээс 2024 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 53 хуулийн этгээд, 453 иргэн бүртгэгдсэн байна. Энэхүү үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн мэргэжлийн үйлчилгээнд үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын олборлогчид, боловсруулагчид, үйлчилгээ үзүүлэгчид, худалдаа арилжаа эрхлэгчид, салбарын зохицуулагчид гэх мэт салбар тус бүрийн түвшинд салбарын үйл ажиллагааг эрхэлдэг нь салбар дундын зохицуулалт шаардлагатай гэдгийг илэрхийлдэг.

Аливаа улс орны хөгжил дэвшил нь нийгмийн баялгийг хэрхэн бүтээж, ашиглаж байгаагаас шууд хамааралтай. Манай улсын хувьд газар нутаг өргөн уудам, байгалийн баялаг ихтэй, хүн ам, ажиллах хүчний нөөц багатай ч нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг их юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос энэхүү салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, зохицуулалтын орчныг боловсронгуй болгохдоо олон улсын жишигт нийцүүлсэн буюу ковид цар тахлын дараах чиг хандлагын хүрээнд судалж, үндэсний дасан зохицох төлөвлөгөөнд тулгуурлан, зохих асуудлыг тусгуулах, боловсронгуй болгоход чиглэн ажиллаж байна.

Түүнчлэн салбар дундын оролцоонд тулгуурласан нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд уламжлалт салбаруудыг кластержүүлэхэд судалгаа, шинжилгээний ажлыг эхлүүлэх, эдийн засгийн хөгжлийн динамик бүтцийг шинжлэх хийгээд түүнд шаардлагатай тоо мэдээллийг цуглуулах, улмаар кластерийн бодлого боловсруулах нь зайлшгүй болж байгаа.

Цаашид инновацад суурилсан, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын татварын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр цогц арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлэхэд “Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран ажиллана.

2024 оны 04 дүгээр сард Монгол Улсын Их Хурлаас Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж дагаж мөрдөх тул мэргэжлийн нэгдсэн холбоотой илүү өргөн хүрээнд хамтран ажиллах эрх зүйн үндэс бүрдэнэ гэж үзэж байна. Энэ хүрээнд тус холбоотой салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг шинэчлэх ажлыг хамтран хийнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг болон бусад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, далд эдийн засгийг ил болгох, тодорхойгүй мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахгүй байх, салбарт учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн ажлуудыг тогтмол хийж байна.

Түүний үр дүнгийн нэг хэсэг нь энэ жилийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “Mongolian jewelry&metal expo, forum-2024” арга хэмжээ юм. Энэхүү арга хэмжээг 2022 оноос эхлэн өдгөө 3 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд салбар дундын бодлогын уялдааг хангах, дундын зохицуулагчдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчдийг бодлого зохицуулалтаар дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг нь олон нийтэд сурталчлах, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх зорилготой.

Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбар нь салбар дундын зохицуулалттай гэдгээрээ онцлогтой учир салбарын оролцогчдын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд салбар хоорондын бодлогуудын уялдааг хангах, төрийн байгууллагуудын хамтын харилцааг зохицуулах шаардлага үүссэн. Иймд “Mongolian jewelry&metal expo, forum-2024” арга хэмжээний үеэр төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран салбарт тулгамдаж буй асуудлын шийдлийг хамтаараа хэлэлцэн салбар дундын оролцоонд тулгуурласан хэрэгжүүлэх арга хэмжээ буюу “Зөвлөмж”-ийг тухайн байгууллага бүрээр гаргаж, холбогдох 14 байгууллагад хүргүүлсэн бөгөөд 2024–2025 онд хийх ажлыг байгууллагын төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна.

Тухайлбал, салбарын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, стандарт тогтоох, бүтээгдэхүүний нэгдсэн ангиллын код, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр болон эдийн засгийн код зэрэгт санал өгөх, судалгаа шинжилгээ хийх, статистик мэдээллийн нэгдсэн сан үүсгэх зэрэг арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөлтэй уулзаж, салбарын хөдөлмөр эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох, үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтод байх, салбарын ангилалд дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах, салбарын онцлогт тохирсон сургалтуудыг хийх зэрэг тулгамдаж буй олон асуудлаар цаашид хамтран ажиллахаар санал солилцсон.

Мөн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийнхээ хүрээнд салбарт нийтийн ашиг сонирхол, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, стандартчилал, сорьцын хяналтын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Стандарт, хэмжил зүйн газартай хамтын ажиллагааг өргөжүүлсэн.

Энэ хүрээнд үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн олборлогчид, үйлдвэрлэгчид, арилжаалагчдын сорьцын хяналтаар дамжсан бүтээгдэхүүн үйлчилгээний стандарт боловсруулах техникийн хороог байгуулахаар ажлын хэсэг томилох, холбогдох статистик мэдээллийг харилцан солилцож, цаашид хийх ажлаа төлөвлөн ажиллаж байна.

Засгийн газраас “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг батлан, үр дүнтэй хэрэгжүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр урт хугацааны стратегийг төлөвлөх, холбогдох төрийн байгууллагуудын оролцоог тодорхойлох хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 54 дүгээр тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023–2030)”-г баталсан.

Иймд тус төлөвлөгөөнд тусгагдсан хамаарах ажил үүргийн хэрэгжилтийг хангаж, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын онцлог болон эрсдэлд тохирсон бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, ФАТФ-ын дараагийн шатны харилцан үнэлгээний явцын тайлагналд бэлтгэх буюу салбарын эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, технологид суурилсан хяналт шалгалтын арга техникийг нэвтрүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Дашрамд дурдахад технологийн өөрчлөлтийн нөлөөгөөр бүхий л салбарын уламжлалт бизнес маш хурдацтай өөрчлөгдөж, зах зээл хувьсаж, урьд өмнө нь зохицуулалтад байгаагүй шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтрэх, өмнөх зохицуулалт үеэ өнгөрөөх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ салбар дамнан хөгжиж өөр хооронд нь ангилан ялгахад хүндрэлтэй болж байгааг бид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Дээрх бүгдээс үүдэн салбарын зохицуулалтын давхардал, хийдэл үүссэнээр зах зээлийн хяналт, зохицуулалтын орчинд холбогдох өөрчлөлтүүдийг оруулах шаардлага урган гарч байгааг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч байгааг холбогдох судалгаануудаас харж болно.

Монгол Улсын хувьд технологийн хөгжил, шинэ эриний чиг хандлагыг суурь болгон шинэ дэлхийд тэргүүлэх салбарын зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс салбар дундын оролцоонд тулгуурласан нийгмийн хөгжлийг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг бий болгохдоо бодлогын уялдааг хангаж, салбар дундын зохицуулагчдын хамтын ажиллагааг эрчимжүүлэхийг гол зорилго болгож байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ “В+,ТОГТВОРТОЙ” ТҮВШИНД ХҮРЛЭЭ



Фитч (Fitch Ratings) зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас Монгол Улсын 2024 оны зээлжих зэрэглэл “В+тогтвортой” болж

сайжирсныг зарлалаа. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ ахихад хэд хэдэн зүйл голлон нөлөөлжээ. Ялангуяа уул уурхайн салбарын өсөлт болон Монгол Улсын эдийн засгийн эрсдэл даах чадвар сайжирсан нь онцлох хүчин зүйл болсон байна.

Тус агентлагийн төсөөллөөр нүүрс, зэсийн олборлолтын өсөлт болон уул уурхайн бус салбарын өсөлтийн нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг 2024–2026 онд дунджаар 6 хувийн өсөлт үзүүлэх хүлээлттэй байгаа бөгөөд энэ нь бусад “В” зээлжих зэрэглэлтэй орнуудын дундажтай харьцуулахад өндөр үзүүлэлт аж. Мөн Монгол Улсын Засгийн газар өрийн удирдлагын оновчтой, зөв бодлогыг хэрэгжүүлж гадаад өрийн дарамтыг бууруулж чадсан, санхүү, төсвийн сахилга бат, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь уул уурхайн зах зээлийн олон улсын үнийн бууралтад тэсвэртэй болсныг онцолсон байна. Түүнчлэн уул уурхайн салбарын өсөлтийн нөлөөгөөр манай улсын нэг хүнд ногдох ДНБ өсөж, бусад “В” үнэлгээтэй орнуудаас өндөр гарсныг дурдсан байна.

Зээлжих зэрэглэл нь тухайн улсад хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг нэмэгдүүлэх, зах зээл дээрх хүүгийн түвшнийг бууруулах, тухайн улсын төр, хувийн хэвшил, банк, санхүүгийн байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтын зардлыг бууруулахад шууд нөлөөлдөг тул эдийн засгийн хөгжлөө дэмжих, тогтвортой өсөлтийг бий болгоход чухал ач холбогдолтой үзүүлэлт юм.

### ДААТГАЛЫН САЛБАРЫН АНХНЫ БОНЗ-ЫН ТАЙЛАН ГАРЛАА



Олон улсын хэмжээнд дэлхийн дулаарал, орчны бохирдол, озоны давхаргын цоорол зэрэг хүрээлэн буй орчны

өөрчлөлттэй тэмцэх зорилгоор тогтвортой хөгжлийн бодлогыг баталж, тогтвортой санхүүжилтийн зарчмыг нэвтрүүлээд байна. Манай улсын хувьд ч Парисын хэлэлцээр болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг

бууруулах, байгаль орчин нийгэмд ээлтэй, хүртээмжтэй, сайн засаглалтай, чанартай боловсрол олгох чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. Санхүүгийн зохицуулах хороо энэ хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилгууд болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын нэг хэсэг болох Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлангийн удирдамжийг боловсруулсан. Үүний дагуу санхүүгийн байгууллагууд БОНЗ-ын тайланг тайлагнаж эхлээд байна.

### ДААТГАЛЫН САЛБАРЫНХНЫ ДУНД ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Санхүүгийн зохицуулах хороо даатгалын компаниуд болон арилжааны банк, “Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын банкны холбооны төлөөлөлд зориулж хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Энэ үеэр “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”, “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д оруулж буй нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулж санал солилцсон юм. Тодруулбал, ипотекийн даатгалын үндсэн зарчим болон олон улсын чиг хандлагад нийцүүлэн зээлдэгчдийг амь насны даатгалд бүрэн хамруулах зорилгоор “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсныг танилцуулсан юм. Мөн урт хугацааны даатгалыг нэвтрүүлэх нөхцөлийг бий болгох зорилгоор даатгалын хоёр компани болон “Төрийн банк” ХК-тай энэ чиглэлд хамтран ажилласан ажлын үр дүнгийн талаар мэдээлэл өглөө. Харин “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийг олон улсын сайн жишигт суурилан нэмэлт өөрчлөлт оруулсны зэрэгцээ банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой оруулсан нэмэлт, өөрчлөлтийг мөн танилцуулж оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлээ.

## БАЙР СУУРЬ

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТӨЛӨӨЛӨЛ ФАТФ–ЫН ДЭРГЭДЭХ ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН БҮЛЭГТ АЖИЛЛАХААР СОНГОГДОВ

*Хяналт шалгалт зохицуулалтыг газрын мөнгө угаахтай тэмцэх албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Ганчимэгтэй ярилцлаа.*



**Сайн байна уу. Юуны өмнө Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–ын Виртуал хөрөнгийн харилцаа холбооны Бүлэг (Virtual Asset Contact Group (VACG))–т Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)–ийг төлөөлж ажиллахаар сонгогдсонд баяр хүргэе. VACG нь ямар чиг үүрэгтэй бүлэг вэ?**

Баярлалаа. Сүүлийн жилүүдэд технологийн үсрэнгүй хөгжил дэвшил нь санхүүгийн зах зээлд хурдацтай нэвтэрч, шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэ боломжуудыг бий болгож, санхүүгийн салбарт томоохон хувьслыг бий болгосон. Гэсэн хэдий ч дэвшилтэт технологийг ашиглаж үндэстэн дамнасан санхүүгийн гэмт хэрэг үйлдэх, хууль бус үйл ажиллагаанд ашиглах тохиолдлууд олон улсад гарсаар байна. Үүнтэй холбоотойгоор ФАТФ–аас Техникийн зөвлөмж 15 (Шинэ технологи)–ыг шинэчилж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ)–дийг бүртгэх, хяналт зохицуулалтад оруулж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэхийг шаардсаны дагуу улс орнуудад Зөвлөмж 15–ын биелэлтийг хангуулах чиглэлээр хяналт тавих, биелэлтийг хангуулах, туслалцаа үзүүлэх зорилгоор ФАТФ–ын VACG бүлгийг 2019 оны 06 дугаар сард байгуулсан.

VACG бүлэг нь ВХҮҮ–ийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх (МУТСТ)–тэй холбоотой чиг үүргийн талаар мэдээлэл өгөх, чадавхыг бэхжүүлэх ажлуудыг зохион байгуулах, аяллын дүрэм буюу “travel rule”–ийг хэрэгжүүлэх техник шийдлүүдийг боловсруулахад ВХҮҮ–ийн салбартай харилцан уялдаатай ажиллах, улс орнууд ФАТФ–ын шинэчилсэн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад

хяналт тавих, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох замаар ФАТФ–ын зөвлөмжийн виртуал хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөөллийг шинжлэх, ФАТФ–ын Бодлого, хөгжлийн бүлгийн виртуал хөрөнгийн талаар авч хэрэгжүүлж буй ажлуудыг дэмжих гэсэн нийт 4 үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

**Энэхүү бүлгийн гишүүнчлэл, сонгон шалгаруулалт ямар хэлбэрээр явагддаг, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийг яагаад сонгох болсон талаарх мэдээллийг өгөхгүй юу.**

2024 оны 06 дугаар сарын хурлын шийдвэрээр ФАТФ–ын бүс нутгийн байгууллагуудаас 2 төлөөллийг тус бүлгийн хуралд оролцуулах шийдвэрийг гаргасан. VACG бүлгийн оролцогчид уулзалт, хэлэлцүүлгээр өөрсдийн туршлагыг хуваалцаж, VACG бүлгийн ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох үүрэгтэй. 2024 оны 08 дугаар сард энэхүү бүлэгт АНДМУТБ–ийн гишүүн орнуудаас ажиллах улсыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд Монгол Улсаас сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг АНДМУТБ–т хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор 2024 оны 09 дүгээр сард АНДМУТБ–г төлөөлж, VACG бүлэгт манай Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны албан хаагчийг сонгон шалгаруулсан тухай мэдээллийг ирүүлсэн.

Ингэснээр, тус Хороо Монгол Улсын төдийгүй, 41 улсын гишүүнчлэл бүхий АНДМУТБ–ийн бүлгийг төлөөлж ФАТФ–ын дэргэдэх VACG бүлэгт ажиллахаар болсон. АНДМУТБ–ийг төлөөлж 2 гишүүн ажиллахаас Хорооны албан хаагч, түүнчлэн АНДМУТБ–ийн секретариат дээрх бүлгийг төлөөлж ажиллана. Энэхүү бүлэгт 100 гаруй гишүүд ажиллаж байгаа бөгөөд ФАТФ–ын дэргэдэх гишүүн байгууллагуудын төлөөллөөс гадна олон улсын донор байгууллагууд ажиллаж байна.

**Энэ бүлэгт ажилласнаар манай улсын хувьд ямар ач холбогдолтой вэ?**

Виртуал хөрөнгийн зах зээл нь урьдчилан тааварлах боломжгүй, байнга хувьсан өөрчлөгдөж байгаа учраас улс орнууд энэхүү стандартыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл учирсаар байна. ВХҮҮ-ийн үйл ажиллагааг хяналт, зохицуулалтад хамруулж, ФАТФ-ын стандартыг хэрэгжүүлэх, МУТСТ шаардлагыг мөрдүүлж, эрсдэлийг бууруулах чиглэлээр Хороо шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байна. Хороо зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой идэвхтэй ажиллаж, аяллын дүрмийн шаардлагыг стандартад нийцүүлж, уян хатан хэрэгжүүлэхээр тогтоож, ВХҮҮ болон мэргэжлийн холбоотой идэвхтэй хамтарч ажиллаж байна. Үүний үр дүнд ФАТФ-аас Техникийн зөвлөмж 15-ын хэрэгжилтийг “хагас хэрэгжсэн”-ийг “дийлэнх нь хэрэгжсэн” болгож 1 шатаар ахиулсан. АНДМУТБ-ээс манай улс бөгөөд Хорооноос авч хэрэгжүүлсэн ажлыг үнэлж, бусад орнуудтай туршлага хуваалцах боломжтой гэж үзэн дээрх бүлэгт ажиллуулахаар сонгон шалгаруулсан гэж үзэж байна.

Мөн ач холбогдлын хувьд тухайлбал, тус Хорооноос VACG бүлэгт орж ажилласнаар стандарт боловсруулагч, олон улсын байгууллага, донор байгууллагуудтай хамтран ажиллах боломжтойн сацуу Техникийн зөвлөмж 15-ын цаашдын бодлогыг тодорхойлох, чиг хандлагыг дүгнэх ажлыг хамтран гүйцэтгэх боломжтой болж байна.

**Цаашид VACG бүлэг ямар ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна вэ?**

Энэхүү салбар нь хурдацтай хувьсан өөрчлөгдсөнөөр мэдээллийг нуун далдлах, нарийн төвөгтэй болгох механизм нарийсаж, ялган таних, тогтоон илрүүлэхэд хүндрэлтэй болж байна. Үүнтэй холбоотой хувьсан өөрчлөгдөж буй зах зээлд МУТСТ бууруулах арга хэмжээг идэвхжүүлэх ажлыг хэрэгжүүлэх, оффшор ВХҮҮ болон DEFI, төвлөрсөн бус арилжаа эрхлэгчдийн эрсдэлийг бууруулах, аяллын дүрмийн хэрэгжилтийг хангах, Техникийн зөвлөмж 15-ын хэрэгжилт хангалтгүй орнуудыг олон улсын донор байгууллагуудтай зуучилж, техник туслалцаа авахад туслалцаа үзүүлэх, бүлгийн үйл ажиллагааны 2 жилийн замын зургийг гаргах зэрэг ажлууд тодорхой үе шаттайгаар хийгдэж байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2024 оны 06 дугаар сарын ээлжит хуралдаанаар VACG бүлгийн үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгч, цаашид олон улсын хэмжээнд ФАТФ-ын Зөвлөмж 15 (Шинэ технологи)-ын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатайг тодотгосон. Одоогийн байдлаар ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр өндөржүүлсэн хяналтад орсон орны жагсаалт буюу “саарал” жагсаалтад нийт 21 улс, харин өндөр эрсдэлтэй орны жагсаалт буюу “хар” жагсаалтад БНАСАУ, Иран улс болон Мьянмар улсууд багтсан хэвээр байна.

**Мэдээлэл өгсөнд баярлалаа.**



## ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

### ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Улсын Их Хурлаас Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 онд баталж өнгөрсөн оноос мөрдөж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх хугацаанд хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхэлж байсан компаниуд бүтцийн өөрчлөлт хийж өөр хуулийн этгээдэд үйл ажиллагаагаа шилжүүлэх, эсхүл шинэ хуулийн этгээд байгуулж үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах шаардлага тулгарсан.

Үүнтэй холбоотойгоор аудит болон хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг давхар эрхэлдэг байсан Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэлтэй зарим компаниудын хувьд “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын зарим нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 248 дугаар

тогтоолоор холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хүрээнд өөрчлөн зохион байгуулагдсан хуулийн этгээдүүдийн хувьд тус Хороонд үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлэхтэй холбоотой журмын зарим нөхцөл, шаардлагыг хөнгөвчилсэн.

Тухайлбал, өмнө нь хөрөнгийн үнэлгээчин нь заавал тухайн хуулийн этгээдийн үндсэн ажилтан байхыг шаарддаг байсан бол нэмэлт, өөрчлөлтөөр хөрөнгийн үнэлгээчин нь 2-оос доошгүй жилийн хугацаанд хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд ажиллаж, хөрөнгийн үнэлгээ хийсэн байх шаардлага тавигдсан. Мөн Хөрөнгийн үнэлгээний тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор өөрчлөн зохион байгуулагдаж, Хороонд бүртгүүлэх хүсэлтээ өгсөн хуулийн этгээдийг хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг 3-аас дээш жил тасралтгүй эрхэлсэн байх зэрэг шаардлагаас чөлөөлсөн.

#### КАСТОИАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А-169/283 дугаар хамтарсан тушаалаар “Кастодианы үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталж, ЗХХА-ын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээ.

Тус журам нь 9 бүлэгтэй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хязгаарлалт, эрх, үүргийг тодорхойлох, эрсдэлийн удирдлага, харилцагчийн хөрөнгийн хадгалалт, бүртгэл, кастодианы

үйлчилгээ үзүүлэх гэрээ, мэдээллийн ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулсан.

“Кастодианы үйл ажиллагааны журам”-ын шинэчилсэн найруулгаар үнэт цаасны тухайлсан бүртгэл хөтлөх, өмчлөх эрхийг баталгаажуулах харилцаа тодорхой болж, кастодианы үүрэг хариуцлага, мэдээллийн ил тод байдал, үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон кастодиан хоорондын уялдаа холбоо сайжирч, харилцагчийн хөрөнгийг өөр кастодианд шилжүүлэх болон үнэт цаасыг тулган баталгаажуулах хугацаа багасах зэрэг эерэг үр дүн гарах ач холбогдолтой.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## НОГООН БОНД

### ТоС Холбооны ногоон удирдамжийн хэсгээс

Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны (ICMA) гаргасан олон улсад зөвшөөрөгдсөн гол стандарт болох Ногоон бондын зарчмуудад (НБЗ) үндсэн 4 төрлийн ногоон бондыг тодорхойлжээ. Үүнд:

- *Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах стандарт ногоон бонд:* Бондын төлбөрийн үүргийг бонд гаргагч бүрэн хариуцах (recourse-to-issuer), НБЗ-ын хүрээнд гаргасан өрийн хэрэгслийг хэлнэ. Бонд нь бусад бондтой адил зээлжих зэрэглэлтэй бөгөөд бонд гаргагчийн хөрөнгөөс бүрэн нөхөгддөг.
- *Орлогоос төлөгдөх ногоон бонд:* Бондын төлбөрийн үүргийг бонд гаргагч эд хөрөнгөөрөө бүрэн хариуцаагүй (non-recourse-to-issuer), төлбөрийн үүрэг нь татвар, хураамж зэрэг орлогын урсгалаар баталгаажсан, бондын эх үүсвэрийг холбогдох, эсхүл хамааралгүй ногоон төсөлд зарцуулах нөхцөлтэй, НБЗ-ын дагуу гаргасан өрийн хэрэгсэл юм. Жишээ нь: төрийн өмчит нийтийн аж ахуйн нэгжийн ногоон бонд нь нийтийн аж ахуйн үйлчилгээний хөлс, хураамжийн орлогоор баталгаажсан байдаг.
- *Төслийн ногоон бонд:* Нэг эсхүл хэд хэдэн ногоон төслийн санхүүжилтэд зориулагдах, бонд эзэмшигч нь төслийн эрсдэлийг хамтран үүрэх, бонд гаргагч (өөрийн хөрөнгөөр) бүрэн хариуцах, эсхүл хариуцахгүй байх нөхцөлтэй, НБЗ-ын дагуу гаргасан өрийн хэрэгсэл юм. Жишээ нь: салхин паркийн төслийг санхүүжүүлэх бонд, төслийн

тодорхой эд хөрөнгө болон баланс дахь хөрөнгөөр баталгаажсан.

- *Үнэт цаасжуулсан ногоон бонд:* Нэг эсхүл хэд хэдэн ногоон төслүүдээр баталгаажсан, тухайлбал барьцаат бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас болон бусад баталгаат бүтцээр гаргасан, эсхүл НБЗ-ын дагуу гаргасан өрийн хэрэгслийг хэлнэ. Бондын эргэн төлбөр нь эхний ээлжинд баталгаажуулж буй хөрөнгийн мөнгөн урсгалаар баталгаажсан (ипотекийн зээлийн эргэн төлбөр зэрэг) байдаг.

Ногоон бонд нь бонд гаргагч болон хөрөнгө оруулагчид хэд хэдэн давуу талыг бий болгодог. Ногоон бонд гаргагчид бий болох гол ашиг тус нь нэг талаас байгаль орчинд ээлтэй, ногоон, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагчдыг татсанаар хөрөнгө оруулагчдын хүрээ өргөжин тэлж, нөгөө талаас ногоон бонд гаргаснаар олон нийтэд эерэг дохио өгч, мэдээллийн хэрэгслийн анхаарлын төвд хүрдэг. Зарим тохиолдолд анхдагч зах зээлд зарлахад үнийн давуу тал бий болдог. Хөрөнгө оруулагчдын хувьд ногоон бонд нь хөрөнгө оруулалтын өгөөжийг золиослолгүйгээр байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйл ажиллагааг санхүүжүүлэх хэрэгсэл/хувилбар болдог. Бонд нь сайн танигдсан хөрөнгө оруулалтын хэрэгсэл бол ногоон бонд нь ердийн бондтой харьцуулахад эрсдэл-өгөөжийн үзүүлэлттэй, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх хувилбар болдог. Мөн ногоон бондын ил тод байдал нь бонд гаргагчийн засаглалын талаар нэмэлт мэдээлэл, баталгаа болдог.<sup>1</sup>

<sup>1</sup> Олон улсын санхүүгийн корпораци, Тогтвортой банкуудын холбоо (2018). Ногоон бондын зах зээлийг хөгжүүлэх нь судалгааны тайлан. <https://www.ifc.org/wps/wcm/connect/37797d8bc7c1-4361-91831e038b225b5a/SBN+Creating+Green+Bond+Markets+Report+2018.pdf?MOD=AJPERES&CVID=mqtaapl>.

## Ногоон бондын удирдамж яагаад/юунд хэрэгтэй байдаг вэ?

Ногоон бондын удирдамж бэлтгэх нь 2 гол шалтгаантай:

- I. Ногоон өрийн хэрэгслийг гаргахтай холбоотой зардал, үйл ажиллагааны талаарх тодорхой бус байдлыг арилгах;
- II. Ногоон бонд гаргах үйл ажиллагааг хурдасгах.

Удирдамж нь:

- Дотоодын ногоон бондыг уур амьсгал, дэд бүтцийг хөгжүүлэх үндэсний зорилгуудтай уялдуулж, улмаар улс орны тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглүүлэх, уялдуулах;
- Ил тод байдлын өндөр стандарт, хараат бус дүгнэлт, байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага, тайлагнал, тогтмол хяналт хийх байдлаар зах зээлийн шударга, тэгш байдлыг хангах;
- “Ногоон” ангилалд багтах төслүүдийг тодорхой болгосноор нүүрстөрөгч бага ялгаруулах, ногоон бонд гаргахад бодлогын дэмжлэг бүрдүүлэх;
- Үйл ажиллагааны зардлыг бууруулж зах зээлийн цар хүрээг нь нэмэгдүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлдэг.

## Ногоон бондын танилцуулга гэж юу вэ?

Ногоон бондын танилцуулга нь НБЗ-ын заавал хэрэгжүүлэх шаардлагатай биш. Гэхдээ, бонд гаргагч өөрийн гаргаж буй ногоон бондын мэдээллийг хөрөнгө оруулагчид болон бусад оролцогчдод хүргэх Ногоон бондын танилцуулгыг бэлтгэх нь зах зээлийн жишиг болсон. Европын Холбооны Ногоон бондын стандарт баримт бичигт Ногоон бондын танилцуулгыг заавал бэлтгэх ёстой гэж заасан байдаг. Европын холбооны Ногоон бондын стандарт баримт бичигт оруулсан Ногоон бондын танилцуулга бэлтгэх загвар нь Ногоон бондын зарчмуудтай нийцтэй байдаг тул Монгол Улсын холбогдох заавар, журамд тусган хэрэглэхийг зөвлөж байна. Ногоон бондын танилцуулгын зорилго нь бонд гаргагчийн ерөнхий стратеги, бондын хөрөнгөөр санхүүжигдэх төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, удирдлага, тайлагналын үйл явц, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар шаардлагатай үнэлгээ, дүгнэлт гаргуулах төлөвлөгөө, мөн Ногоон таксономид нийцтэй эсэхийг холбогдох талуудад тайлбарлах явдал юм.

## Ногоон бонд “ногоон” шалгуурыг хангахгүй бол яах вэ?

Ногоон бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийг Ногоон бондын танилцуулгад заасан “ногоон” зорилгын дагуу ашиглаагүй, эсвэл санхүүжигдсэн төсөл нь заасан “ногоон” шалгуурыг хангахгүй бол юу болох вэ? Үүнийг “ногоон үүргийн зөрчил”

(green default) гэж нэрлэдэг. Энэ нь бонд гаргагчийн хувьд нэр хүндийн томоохон асуудал дагуулж болзошгүй. Ийм нөхцөл үүссэн тохиолдолд гарах үр дагаврын талаар НБЗ болон ASEAN Ногоон бондын стандарт баримт бичигт тусгайлан заагаагүй. Гэсэн хэдий ч бусад холбогдох стандартууд эсвэл гэрээний үүргийн хүрээнд болзошгүй үр дагавар, хариуцлагын асуудал сөхөгдөх болно. Уур амьсгалын бондын стандартын дагуу гэрчилгээжүүлсэн ногоон бонд ийнхүү “ногоон зөрчил” үүссэн тохиолдолд бонд гаргагч Уур амьсгалын бондын санаачилгын Удирдах Зөвлөлд нэг сарын дотор тайлбар гаргах шаардлагатай бөгөөд Зөвлөлөөс асуудлыг засаж залруулах арга хэмжээг санал болгож болно. Санал болгосон арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй бол тухайн бондын гэрчилгээг хүчингүй болгож, энэ тухай зах зээлд мэдээлдэг. Гэрчилгээг хүчингүй болгох, бонд гаргагчийн нэр хүндэд сөрөг нөлөө бий болохоос аливаа нэмэлт санкц арга хэмжээ байдаггүй. Ихэнх тохиолдолд, ногоон бондын гэрээний баримт бичигт ногоон гэрчилгээ хүчингүй болох нь “зөрчлийн тохиолдол”-д тооцогдохгүй байдаг тул бондын хөрөнгө оруулагчид нэмэлт арга хэмжээ авах боломж хязгаарлагдмал байдаг. Зарим ногоон мандат бүхий хөрөнгө оруулагчид уг бондыг хоёрдогч зах зээлд алдагдал үүрэн борлуулахаас аргагүйд хүрэх тохиолдол байдаг.

Бондын гэрээний хүрээнд үүнийг зохицуулдаг нэг шийдэл нь, “ногоон зөрчил”-ийн тохиолдолд бонд гаргагч нь хөрөнгө оруулагчид нэмэгдүүлсэн хувиар купон төлөх нөхцөл тусгаж болно. Европын Холбооны Ногоон бондын стандарт баримт бичиг нь энэхүү шийдлийг дэмжсэн байдалтай байдаг. Кенийн зохицуулагч байгууллага “ногоон зөрчил”-ийн тохиолдол үүссэн нөхцөлд дараах арга хэмжээг авна гэж заасан байдаг. Үүнд:

Гаргасан зөрчлийг арилгах арга хэмжээг авах талаар бонд гаргагчтай тохиролцох, хэрэв зөрчлийг арилгаж чадахгүй бол эрх бүхий байгууллагаас ногоон бондын “ногоон” шошгыг хүчингүй болгох;

Эрх бүхий байгууллагаас хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалах үүднээс бонд гаргагчид бусад боломжит арга хэмжээ авах боломжтой бөгөөд нээлттэй үнэт цаасны хувьд Найробигийн хөрөнгийн бирж өөрийн дүрэм журмын дагуу холбогдох арга хэмжээг авах;

“Ногоон угаалт” нь Кени улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулагчдыг хууран мэхэлсэн, хуурамч мэдээлэл тараасанд тооцогддог тул хуулийн хариуцлага хүлээх ёстой болдог.

Монголын хувьд Уур амьсгалын бондын санаачилгаас баримталдаг зарчмын дагуу буюу зөрчлийг арилгах арга хэмжээ санал болгож, зөрчлийг арилгаж чадахгүй тохиолдолд ногоон шошгыг хүчингүй болгон, зөрчлийн талаар зах зээлийн оролцогчдод мэдээлэх хэлбэрээр шийдвэрлэхийг зөвлөж байна.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

### НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ


Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталж, нээлттэй хувьцаат компаниудад кодексийг дагаж мөрдөхийг үүрэг болгосон. Түүнчлэн СЗХ-ны даргын 2022 оны 336 дугаар тушаалын хавсралтаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдамж”-ын дагуу “Монголын хөрөнгийн бирж”-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн кодексийн хэрэгжилтийг 2023 онд үнэлж, зэрэглэл тогтоох ажлыг хэрэгжүүлж эхэлсэн юм.

Нээлттэй хувьцаат компанийн кодексийн хэрэгжилтэд 2023


оны эхний хагас жилд хийсэн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ 58.0 хувь байсан бөгөөд 2023 оны жилийн эцэст 65 хувьд хүрч, ахиц дэвшлийг үзүүлж байсан.



Санхүүгийн зохицуулах хороо 2024 онд Хөрөнгийн биржид бүртгэлтэй 108 ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн, үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг тооцон, тайлангаа ирүүлсэн 37 компанийн давтан үнэлгээг хянан баталгаажуулахад эхний хагас жилийн байдлаар кодексийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 18.7 хувиар өсөв.

**Зураг.** “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээнд суурилсан хугацаатай чиглэл, үүргийн дагуу гарсан өөрчлөлт



**Зураг.** “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ болон биржийн бүртгэлийн ангиллын харилцан хамаарал



**Зураг.** Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний насжилт ба эзэмшсэн мэргэжил**Зураг.** Цахим хуудсандаа ил болгосон мэдээлэл

Компанийн засаглалыг нэвтрүүлэх нь бизнесийн үйл ажиллагааны урт хугацааны өгөөжийг хангах төдийгүй хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд суурилсан шударга, нээлттэй зах зээлийн орчин бүрдэхэд эергээр нөлөөлдөг тул нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Компанийн засаглалын зэрэглэл нь тухайн компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийх мэдээлэл болж өгснөөр хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрсдэлгүй шийдвэр гаргалтад эергээр нөлөөлөх ач холбогдолтой юм.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ШИЛДЭГ 10: ФИНТЕК ЗОХИЦУУЛАГЧИД

Шинэ технологиуд санхүүгийн үйлчилгээний зах зээлд өргөн нэвтэрч, финтек гарааны компаниуд шинэлэг шийдлүүдээр хөгжихийн хэрээр технологийн хэрэгжилт аюулгүй байдал, хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах үүрэгтэй зохицуулагч байгууллагуудын үүрэг улам чухал болж байна. Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ финтек салбарыг зохицуулж буй хамгийн чухал зохицуулагч байгууллагуудын талаар мэдээ мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Энэхүү мэдээллийг Fin-tech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.

#### ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ФИНТЕК АЖЛЫН ХЭСЭГ (IFWG)



Өмнөд Африк нь Африк тивд финтек салбарын хамгийн том төв болж байна. Финтекийн хурдацтай хөгжил нь орон нутгийн зохицуулагчдын анхаарлыг ихээхэн татаж байгаа бөгөөд бодлого

боловсруулагчид хамтран IFWG буюу Засгийн газар хоорондын Финтек ажлын хэсгийг байгуулжээ. Энэхүү ажлын хэсэгт тус улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд багтдаг.

#### ФИЛИППИНИЙ ТӨВ БАНК (BSP)



Филиппиний Төв банк (BSP) нь тус улсын санхүүгийн үйлчилгээний гол зохицуулагч байгууллага юм. Төв

банк нь “Шинэ Төв банкны тухай” хуулийн дагуу банкны үйл ажиллагааг хянаж, зохицуулах эрхтэй. Мөн тус банк мөнгөний бодлого хэрэгжүүлж, банкны системийг хянаж, санхүүгийн тогтвортой байдлыг дэмждэг. Төв банк нь санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг бизнесүүд, зээл олгодог байгууллагууд болон төлбөрийн системийн операторуудыг зохицуулдаг.

Мөнгөний бодлогын зөвлөл долоон гишүүнтэй бөгөөд банк, зээлийн болон мөнгөний бодлогыг тодорхойлдог.

#### МАЛАЙЗЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО (SC)



HSBC Малайзын Үнэт цаасны хороо (SC) нь 1993 оны Үнэт цаасны хуулиар байгуулагдсан бөгөөд тус улсын хөрөнгийн зах зээлийн гол зохицуулагч байгууллага юм. Тус хороо нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлж, хяналт тавих үүрэгтэй бөгөөд санхүүгийн эх үүсвэрээ өөрөө бүрдүүлэн Сангийн сайдад үйл ажиллагаагаа тайлагнадаг. Малайзын Үнэт цаасны хорооны зорилго нь шударга, ил тод зах зээлийг дэмжиж, өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд оршино. Тус байгууллага нь “Хөрөнгийн зах зээлийн үйлчилгээний тухай” хуулиар зохицуулагддаг тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын дүрэм журам боловсруулж, зах зээлийн үйл ажиллагааг хянах үүрэгтэй.

#### ХОНКОНГИЙН МӨНГӨНИЙ ГАЗАР (НКМА)




Хонконгийн Мөнгөний газар (НКМА) нь Хонконгийн гол санхүүгийн зохицуулагч байгууллага юм. Тус байгууллага нь банкны системийг хянаж, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг хангадаг.

Мөнгө угаахтай тэмцэх болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх удирдамжийг гаргаж, төлбөрийн системийг зохицуулдаг. Мөн Хонконгийн Мөнгөний газар нь болзошгүй

хямралыг шийдвэрлэх төлөвлөгөөг боловсруулж, Хонконгийг дэлхийн санхүүгийн төв байлгах үүрэг гүйцэтгэдэг.

## ЯПОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АГЕНТЛАГ (FSA)



2000 онд байгуулагдсан Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA) нь тус улсын гол зохицуулагч байгууллага юм. FSA нь зохицуулалтын бодлого боловсруулж, санхүүгийн байгууллагуудыг хянан шалгах зах зээлийн оролцогчдыг луйвар болон мөнгө угаах гэмт хэргээс хамгаалах үүрэгтэй. Тус агентлаг нь Засгийн газрын Кабинетын албанд харьяалагддаг бөгөөд комиссар удирддаг тус байгууллага нь Санхүүгийн үйлчилгээний сайдад үйл ажиллагаагаа тайлагнадаг. Мөн FSA нь олон улсын байгууллагуудтай хамтран мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг зохион байгуулдаг.

## АНУ-ЫН ВАЛЮТЫН ХЯНАЛТЫН ГАЗАР (ОСС)



АНУ-ын Валютын хяналтын газар (ОСС) нь АНУ-ын Сангийн яамны хараат бус товчоо бөгөөд 1863 онд байгуулагдсан. Тус байгууллага нь үндэсний банкнууд болон холбооны

хуримтлалын нийгэмлэгүүдийг хянаж, тэдгээрийн хууль ёсны үйл ажиллагааг хангадаг. ОСС нь финтек болон банкнуудын харилцаанд онцгой анхаарч, банкнууд финтектэй холбоотой эрсдэлийг хариуцах ёстой гэж үздэг. Мөн АНУ-ын банкнуудын худалдан авах, нэгдэх үйл явцад илүү хатуу дүрэм санал болгодог. Мөн тус байгууллага АНУ-ын банкнуудад зориулсан худалдан авах, нэгдэх үйл явцын M&A дүрмийг сайжруулах санал гаргасан.

## ЕВРОПЫН БАНКНЫ ГАЗАР (ЕВА)



2011 онд байгуулагдсан Европын Банкны газар (ЕВА) нь Европын банкны салбарын зохицуулалт, хяналтыг хангах үүрэгтэй бие даасан

Европын холбооны байгууллага юм. Парист байрладаг тус агентлаг нь Европын банкны нэгдсэн дүрэм боловсруулах,

банкнуудад стресс тест хийх зэрэг чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус байгууллага нь ЕХ-ны банкны системийн санхүүгийн тогтвортой байдал, шударга байдлыг хадгалахад чиглэн ажилладаг.

## САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР (FCA)



Их Британийн Санхүүгийн үйл ажиллагааны газар (FCA) нь санхүүгийн зах зээлийг хянаж, бараг 45,000 бизнесийн үйл ажиллагааг зохицуулдаг. Тус байгууллага нь засгийн газраас хараат бус боловч HM Treasury-тай хамтран банк, даатгал, хөрөнгө оруулалт зэрэг олон салбарыг хянадаг. FCA нь эрсдэлд суурилсан хяналтын арга барилыг ашиглаж, илүү өндөр эрсдэлтэй бизнес, салбаруудад онцгой анхаардаг.

## ХЭРЭГЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ХАМГААЛЛЫН ТОВЧОО (CFPB)



2011 онд байгуулагдсан АНУ-ын Хэрэглэгчийн санхүүгийн хамгааллын товчоо (CFPB) нь хэрэглэгчийг санхүүгийн салбарт хамгаалах үүрэгтэй хараат бус агентлаг юм. Тус байгууллага нь банк болон бусад санхүүгийн байгууллагуудыг хянаж, шударга үйл ажиллагаа явуулахыг шаарддаг. CFPB нь хэрэглэгчдэд зориулсан санхүүгийн боловсролын хэрэгслүүдийг санал болгож, хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх үүрэгтэй. Байгуулагдсанаасаа хойш тус товчоо нь олон тэрбум долларыг хэрэглэгчдэд буцаан олгох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

## ҮНЭТ ЦААС, БИРЖИЙН КОМИСС (SEC)



АНУ-ын Үнэт цаас, биржийн комисс (SEC) нь 1929 оны Уолл Стритийн хямралын дараа 1934 онд байгуулагдсан бөгөөд үнэт цаасны зах зээл, брокер-дилерүүд болон хөрөнгө оруулалтын зөвлөхүүдийг хянаж ажилладаг. SEC-ийн зорилго нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах, шударга, үр ашигтай зах зээлийг дэмжих, мөн капитал бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. SEC нь мөн криптовалютын Биткойн, Ether-ийн биржээр арилжаалагдах сангуудыг (ETF) зөвшөөрч салбартаа томоохон ахиц дэвшил гаргасан.

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ: ЖИШЭЭ, ЗӨВЛӨМЖ (СУДАЛГААНЫ ҮРГЭЛЖЛЭЛ)

Эхлэл 1–р нүүрт

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### Гүйцэтгэсэн:

Б.Батчимэг, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны дарга,  
batchimeg\_b@frc.mn

Г.Анхзаяа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн,  
ankhzaya\_g@frc.mn

О.Мичидмаа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн,  
michidmaa\_o@frc.mn

#### ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, КЕЙС СУДЛАГДАХУУН

##### Суптекийн чиг хандлага олон улсад

Зураг. Суптекийг нэвтрүүлснээр гарч буй үр дүн



Эх сурвалж: Кэмбрижийн Их Сургууль, Суптекс лаб

Санхүүгийн зохицуулагч байгууллагууд суптекийг ихэвчлэн өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа, эрсдэлийн үнэлгээ, комплаенсын хяналт болон зах зээлийн хяналтын үйл ажиллагаанд ашиглаж байгаа бол их өгөгдөл, хиймэл оюун ухаан нь хамгийн өргөнөөр ашиглагдаж буй технологийн шийдлүүд байна. Хиймэл оюун ухаан болон их өгөгдөл суурилсан суптекс технологи нь зах зээлийн трендийг таамаглах, эрсдэлийг үнэлэх болон системийн эрсдэлийг танихад чухал үр нөлөөтэй.

## Суптекийг нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, хэрэгжүүлэх арга хэмжээ

Суптекийг нэвтрүүлж буй улс орнуудад дараах асуудлууд нийтлэг байдлаар тулгарч байна. Үүнд:

- **Өгөгдлийн нууцлал болон аюулгүй байдал:** ахисан түвшний өгөгдлийн шинжилгээ болон хиймэл оюун ухааны ашиглалт нь өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлын асуудлыг хөндөж буй бөгөөд зохицуулагч байгууллагууд суптекийг нэвтрүүлэхдээ өгөгдлийн найдвартай байдалд анхаарал хандуулан өгөгдөл хамгаалах хууль, стандартуудыг баталж мөрдөх шаардлагатай.
- **Хуулийн системтэй нийцтэй байдал:** өнөөгийн хууль, эрх зүйн орчинд суптекийг шууд нэвтрүүлэх нь зохицуулагч байгууллагуудад сорилт болж буй бөгөөд шинэ технологийг амжилттай нэвтрүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчны шинэчлэлийг харгалзан үзэх шаардлагатай.
- **Зохицуулалтын орчны ойлгомжтой байдал:** суптекийг нэвтрүүлэх тутам зохицуулалтын орчны дүрэм, журамдаа суптек хэрэглээтэй холбоотой өөрчлөлт, шинэчлэлтүүдийг заавал тусган ойлгомжтой байдлаар боловсруулах шаардлага үүсэж байна. Өгөгдлийн засаглал, өгөгдлийг ашиглах ёс зүйн стандарт, хиймэл оюун ухаан болон машин сургалтын ашиглахад анхаарах асуудлуудыг зохицуулалтын баримт бичигтээ хөндөх зайлшгүй шаардлага тулгарч байна.
- **Боловсон хүчнийг чадавхжуулах:** суптекийг амжилттай нэвтрүүлэх гол түлхүүр нь чадварлаг хүний нөөц бөгөөд шинэ тутам хөгжиж буй технологитой ажиллах ур чадвар бүхий хүний нөөцийн эрэлт, хэрэгцээ улам бүр өссөөр байна.

Суптекийг нэвтрүүлж буй улс орнууд нь хяналт, шалгалтын технологийг амжилттай нэвтрүүлэхэд гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаануудыг нэрлэж байна. Суптекийг амжилттай нэвтрүүлэхийн тулд зохицуулагч байгууллага нь нэн тэргүүнд суптекийг нэвтрүүлэх замын зураг, стратеги төлөвлөгөө боловсруулах шаардлагатай бөгөөд одоогийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг үнэлэн, үүндээ суурилан суптекийг нэвтрүүлэх нэн тэргүүний үйл ажиллагаагаа тодруулах нь чухал юм.

Үүний дараагаар суптекийн хөгжүүлэлтийг дэмжих дэд бүтцээ сайжруулах хэрэгтэй бөгөөд өгөгдлийн менежментийн

систем, аналитик, шинжилгээний платформ, кибер аюулгүй байдлын бодлого зэрэг зайлшгүй шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлэх хэрэгтэй. Ингэхдээ мэдээж шинэ тутам нэвтрүүлэх суптек хэрэгслүүд нь тухайн дэд бүтэцтэй нийцэж ажилладаг байх шаардлагатай юм.

Түүнчлэн боловсон хүчнээ чадавхжуулж, сургах нь мөн суптекийг амжилттай нэвтрүүлэх хамгийн чухал орц бөгөөд суптекийн үнэ цэн нь түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглаж чадаж буйгаас ихээхэн хамаарна. Иймд, шинэ технологи, инновацад нээлттэй соёлыг байгууллагадаа дэлгэрүүлэх, төрөл бүрийн боловсон хүчнийг чадавхжуулах хөтөлбөр, сургалтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Санхүүгийн зохицуулагч байгууллагууд өөр хоорондоо болон зах зээлийн оролцогчид, финтек болон санхүү, технологийн компаниудтай хамтран ажиллаж, мэдлэг солилцож байх нь суптекийг амжилттай нэвтрүүлэхэд шаардлагатай алхам юм. Олон улсын байгууллагууд, мэргэжлийн экспертүүд болон технологийн компаниуд нь хяналт, шалгалтын үйл ажиллагаа дахь технологийн практик хэрэглээг үр дүнтэй дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой.

Суптекийг нэвтрүүлэх нь зөвхөн технологийн шинэчлэлийн асуудал биш бөгөөд их өгөгдөл, хиймэл оюун ухаан, машин сургалтыг хэрхэн аюулгүй, ёс зүйтэй байдлаар ашиглах, өгөгдлийн нууцлал, аюулгүй байдал, кибер аюулгүй байдлыг хэрхэн хангуулах тал дээр холбогдох дүрэм, журам, стандартуудыг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөх, мөн хяналт, шалгалтын журам, заавартаа технологи ашиглахтай холбоотой харилцааг тусгаж өгөх шаардлагатай.

### Улс орнуудын кейс

#### Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улсад суптекийг санхүүгийн зохицуулагч байгууллагууд өргөнөөр хөгжүүлэн, нэвтрүүлж байна.

**Холбооны нөөцийн банк:** Холбооны нөөцийн банк нь хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа сайжруулахын тулд ахисан түвшний шинжилгээ болон машин сургалтын технологийг өргөнөөр ашиглаж байна.

- *Хөрөнгийн шинжилгээ (технологи-их өгөгдөл):* Холбооны нөөцийн банк нь зээлийн мэдээллийн дэлгэрэнгүй өгөгдлийг арилжааны банкуудын стресс тестийн шинжилгээнд ашигладаг бөгөөд эдийн засгийн

уналтын үед зээлдэгчид төлбөрийн чадвараа хадгалж чадах эсэх, үүнд үндэслэн банкнуудын хөрөнгийн харьцаа хадгалагдаж буй эсэхэд хяналт тавьдаг.

- *Эрсдэлийн зураглал (технологи–BI, datavis):* Холбооны нөөцийн банк нь шинээр гарч ирж буй эрсдэлийг илрүүлэх, санхүүгийн системийн эмзэг байдлыг тодорхойлохын тулд эрсдэлийн дулааны зураглалыг ашигладаг.
- *Хэлний олборлолт (технологи–ахисан түвшний өгөгдлийн шинжилгээ, эх хэлний боловсруулалт):* хэлний олборлолт нь бичиг баримтаас тодорхой сэдвийн хүрээний мэдээллийг ялгахын тулд дүрэмд суурилсан болон машин сургалтыг ашигладаг технологи юм. Хэлний олборлолтын зорилго нь баримт бичгийн доторх тодорхой төрлийн хэлтэй холбоотой өгүүлбэрүүдийг тодруулах юм. Хэлний олборлолт нь хэрэглэгчид баримт бичгийн багцыг дэлгэрэнгүй судлах, тодорхой төрлийн өгүүлбэрүүдийг баримт бичгээс олборлох, баримт бичгийн ерөнхий агуулгыг шууд тодорхойлоход тусалдаг.

**Үнэт цаас, биржийн хороо:** Үнэт цаас, биржийн хороо нь зах зээлийн гажуудал, дотоод мэдээлэлд суурилсан арилжаа болон бусад луйврын үйл ажиллагааг илрүүлэхийн тулд машин сургалт, хиймэл оюун ухаан зэрэг дэвшилтэт технологийг ашигладаг.

- *Зөрчлийг илрүүлэх дэвшилтэт технологи (технологи–эх хэлний боловсруулалт, машин сургалт):* Үнэт цаас, биржийн хороо нь хууль бус үйл ажиллагааг илрүүлэх үе шатлалт аргачлалыг ашигладаг. Хөрөнгө оруулалтын зөвлөх, менежментийн компаниуд нь зохицуулалтын тайлан мэдээг “hadoop” тооцооллын кластерт нийлүүлдэг бөгөөд Үнэт цаас, биржийн хороо нь тус кластераас их хэмжээний бүтэцлэгдсэн болон бүтэцлэгдээгүй өгөгдлийг авч ашигладаг. Ингэхдээ

эхлээд хяналтгүй сургалтын аргыг ашиглан их өгөгдлөөс захын болон өвөрмөц утгуудыг таньдаг. Уг үр дүнг өмнө нь хийгдэж байсан шалгалтын үр дүнтэй нэгтгэж, хоёр дахь шатны машин сургалтыг гүйцэтгэн эрсдэлийг таамагладаг.

- *Өгөгдлийн шинэчлэл төсөл (технологи–үүлэн тооцоолол):* Үнэт цаас, биржийн хороо нь өгөгдлийн менежментийн чадавхыг нэмэгдүүлэх, мэдээлэл цуглуулах, хадгалах, боловсруулах ажлыг сайжруулахын тулд үүлэн тооцооллыг ашигладаг. Тухайлбал, “hadoop” тооцооллын кластер гэх мэт томоохон өгөгдлийн технологийг ашигласнаар опционы үнийн тайлагнал зэрэг 500 гаруй сая баримт бичигтэй тэнцэх хэмжээний мэдээллийг боловсруулах боломжтой болсон. Үнэт цаас, биржийн хороо нь энэ их хэмжээний өгөгдлөөс зах зээлийн чанар, үнийн статистик зэрэг илүү хэрэгцээтэй мэдээллийг сонгон ашиглах боломжтой.
- *Луйврын магадлалд зориулсан машин сургалт (технологи–их өгөгдөл, машин сургалт, нөхцөлт утгуудад суурилсан шинжилгээ):* Зах зээл дээрх зохицуулалтгүй үйл ажиллагаа, санхүүгийн луйврын магадлалыг урьдчилан таамаглахын тулд Үнэт цаас, биржийн хороо нь машин сургалтын аргыг ашиглаж байна. Үнэт цаас, биржийн хорооны Эдийн засаг ба эрсдэлийн шинжилгээний хэлтэс нь хяналттай болон хяналтгүй машин сургалтын алгоритмуудыг аль, алиныг нь ашиглаж буй бөгөөд хяналтгүй машин сургалт нь өгөгдөл мэдээлэл, өөр дээр нь сургагдан санхүүгийн луйврыг илрүүлэхэд ашиглагддаг. Шинэ мэдээлэл нэмэгдэх тутам машин сургалт нь өнгөрсөн өгөгдлөөс залилан мэхлэлт гэж тодорхойлсон тохиолдол дээрээ үндэслэн дараа, дараагийн санхүүгийн залилан гарах магадлалыг урьдчилан таамагладаг.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД СУПТЕК НЭВТРҮҮЛЭХ САНАЛ

Суптекийг нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, хэрэгжүүлэх арга хэмжээ

### Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хороо (Хороо) нь Монгол Улсын санхүүгийн систем дэх банкны салбараас бусад оролцогчдыг хянаж, зохицуулах чиг үүрэгтэй бөгөөд Хорооны зохицуулалт дор хөрөнгийн зах зээл, даатгалын салбар, бичил санхүүгийн салбарын оролцогчид болох банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоод, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид болон санхүүгийн бус мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчид болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчид зэрэг нийт 3700 гаруй этгээд хамаардаг.

Өнөөгийн байдлаар Хорооны 50 хүрэхгүй хянан шалгагчид эдгээр хуулийн этгээдэд газар дээрх болон зайны хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд Хорооны хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь гар үйлдэл ихтэй бөгөөд зохицуулалтын байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээ, өгөгдлийг баталгаажуулах үйл явц нь автоматажсан биш байгаа нь хянан шалгагчийн хөдөлмөр, цагийг ихээр шаарддаг. Мөн санхүүгийн байгууллагуудын өгөгдлийн тайлангийн дийлэнх нь улирал тутмын хугацааны давтамжтай байгаа нь санхүүгийн системийн эрсдэлийг илрүүлэх хугацааг хоцроож байна. Энэ нь мэдээж санхүүгийн системд тулгарсан аливаа эрсдэлийг цаг тухай бүрээр нь таньж, хариу арга хэмжээг яаралтай авахад хүндрэл үүсгэж буй.

**Зураг.** Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын үйл ажиллагаа сүптек хөгжлийн аль шатанд явж буйг үнэлсэн байдал



Монголбанк

Монголбанк нь арилжааны банкнууд болон төлбөрийн системд оролцогч байгууллагуудад хяналт тавих, санхүүгийн мэдээллийн албыг хариуцах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд зохицуулалтын байгууллагуудаас мэдээлэл авах хэд хэдэн системийг ажиллуулдаг. Үүнд:

- GoAML – Санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор зохицуулалтын байгууллагуудын гаргасан тайланг хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийхэд ашигладаг.
- FINA – хяналт шалгалтын хэлтэс нь зохицуулалттай байгууллагуудаас санхүүгийн тайлан хүлээн авах, дүн шинжилгээ хийх, хяналт тавихад ашигладаг.
- BRMS – BRMS нь банкнууд болон бусад зах зээлд оролцогчдоос тогтмол хугацаанд мэдээлэл цуглуулах зорилгоор дотооддоо боловсруулагдсан систем бөгөөд Монголбанкны Төлбөрийн системийн газар, Судалгаа, статистикийн газар ашигладаг.

## ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Суптекийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь урт хугацаа, хөрөнгө оруулалт шаардсан, нарийн цогц стратегийн үйл ажиллагаа болох бөгөөд цаашид Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд суптекийг нэвтрүүлэхийн тулд илүү нарийвчилсан түвшний шинжилгээ, технологийн аудитыг хийж гүйцэтгэн, түүнд үндэслэсэн стратеги төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй юм. Энэхүү судалгаагаар олон улс орнуудад хэрэгжүүлж буй суптекийн хэрэглээ, тэдгээрийн бодит жишээг судлан, Монгол Улсын санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа хэрхэн явагдаж буйг тоймлон авч үзсэн бөгөөд судалгааны үр дүнд суурилан дараах арга хэмжээний саналыг ойрын, дунд болон урт хугацаанд гэсэн гурван түвшинтэйгээр боловсруулж байна.

### Ойрын хугацаанд:

- Өнөөгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг үнэлэх. Ингэхдээ хяналт, шалгалтын ямар үйл ажиллагаанд технологийг нэвтрүүлэх нэн тэргүүний шаардлагатай байгааг тодорхойлох, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд суптекийн шийдлийг нэвтрүүлснээр хамгийн их үр өгөөж хүртэх, мөн хамгийн бага зардал шаардагдах үе шатуудыг ялгаж тогтоох.
- Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн системийн дэд бүтэц, өгөгдлийн менежмент болон ашиглагдаж буй суптекийн хэрэгслүүдэд аудит хийх. Үүнд өгөгдөл цуглуулах аргачлалууд, комплаенсыг хангуулах үйл ажиллагаа, эрсдэлийн менежментийн бодлого, технологийн ерөнхий архитектур зэргийг хамруулах.
- Суптекийг нэвтрүүлэх бэлэн байдлыг үнэлэх. Суптекийн хэрэгслүүдийг нэвтрүүлэхэд албан хаагчдын ур чадвар хангалттай түвшинд буй эсэх, өнөөгийн мэдээллийн технологийн дэд бүтцийн чадамж хангалттай эсэх, хууль, эрх зүйн зохицуулалт мөн нийцтэй эсэх, зохицуулалтын байгууллагуудын чадавх хангалттай эсэхийг үнэлэх.
- Суптекийг нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж батлах. Ингэхдээ оролцогч талуудын хамтын ажиллагаа, хүний нөөцийг чадавхжуулах, хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийх зэрэг бүхий л шатанд дэлгэрэнгүй төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж батлах. Мөн шаардлагатай санхүүжилтийн төслүүдийг бэлтгэх.
- Хүний нөөцийг чадавхжуулах, техникийн ур чадварыг нэмэгдүүлэх. Өгөгдлийн шинжилгээ, машин сургалт, хиймэл оюун ухааны хэрэглээ, автомат тайлагналын систем зэрэг суптекийн өргөн хэрэглээний программуудын талаар суурь түвшний сургалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.
- Мөрдөгдөж буй зохицуулалтын баримт бичгүүдэд суптекийг нэвтрүүлэхэд зөрчилтэй баримт буй бол

шинэчлэн боловсруулах, суптекийг нэвтрүүлэхэд нийцтэй болгож боловсруулах.

### Дунд хугацаанд:

- Суптекийг нэвтрүүлэх төслүүдийг эхлүүлэх. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд технологи нэвтрүүлэх төслийг ач холбогдлын түвшин, зардал, үр ашгийн шинжилгээнд суурилан нэвтрүүлж эхлэх.
- Суптек нэвтрүүлэх, ашиглах гарын авлага, заавар зөвлөмжийг боловсруулж мөрдөх. Үүнд өгөгдлийн нууцлалыг хангах, кибер аюулгүй байдлыг сахиулах, хиймэл оюун ухааныг зохистой түвшинд ашиглах гарын авлага, стандарт заавар мөн багтана.
- Нэвтрүүлсэн суптекийн хэрэгслүүд, стандарт, дүрэм журмууд олон улсад мөрдөгдөж буй стандартуудтай нийцтэй байдлыг хангуулах.
- Хүний нөөцийг чадавхжуулах ахисан түвшний сургалтуудыг зохион байгуулах, салбарын оролцогчдыг бэлтгэх сургалт, семинарыг мөн зохион байгуулах, суптекийн ашиглалт, ач холбогдол, хэрэглээг зохицуулалтын байгууллагуудад таниулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах.

### Урт хугацаанд:

- Хяналт, шалгалтын үйл ажиллагаанд суптекийг бүрэн нэвтрүүлэх. Бодит цагийн горимоор ажилладаг, эрт илрүүлгийн системтэй эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоонд шилжих, өгөгдөл мэдээллийг тайлангаар хугацааны давтамжтай авах бус шаардлагатай тохиолдолд шууд татан ашиглах боломжтой хяналтын системд шилжих.
- Байнгын сайжруулалт, инновац хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх. Ашиглагдаж буй суптекийн хэрэгслүүдийн үйл ажиллагааг тогтмол үнэлэн, шаардлагатай шинэчлэлт, сайжруулалтыг байнга гүйцэтгэн, хөгжүүлж ажиллах.

## ДҮГНЭЛТ

Санхүүгийн зохицуулагчид хяналт, эрсдэлийн удирдлагыг сайжруулахад хиймэл оюун ухаан, машин сургалт, их өгөгдөл зэрэг технологиудыг ашиглан нэвтрүүлж дэлхийн хэмжээнд суптек маш хурдацтай өсөн хөгжиж байна. Хөгжингүй эдийн засагтай орнууд нэмэлт технологи нэвтрүүлэх чиглэлээр тэргүүлж байгаа бол хөгжиж буй орнууд санхүүгийн хяналтаа сайжруулахын тулд суптекийг идэвхтэй хэрэглэсээр байна. Дэлхий даяар мэдээллийн нууцлалыг хадгалах, зохицуулалтын тогтолцоог тохируулах, зохицуулагчдын хоорондох технологийн ур чадварын зөрүүг зохицуулах асуудалтай нүүр тулсаар байна.

Улс орнууд үр ашгаа дээшлүүлэх, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, шийдвэр гаргах хурдыг нэмэгдүүлэх, зохицуулалтын хэрэгжилтийг хангах, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор суптекийг хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь зохицуулагчдад санхүүгийн салбарын хурдацтай өөрчлөлтийг дагаж, эрсдэлийг илүү үр дүнтэй удирдахад тусална. Үүнд манай Монгол улс ч хамааралтай байна.

Манай улсын хувьд бодит цагийн хяналт, эрсдэлийн динамик үнэлгээний систем хараахан хөгжөөгүй байгаа нь зах зээлд оролцогчдын итгэлийг бууруулах, улам бүр нэмэгдэж буй системийн эрсдэлийг дутуу үнэлэх, эрсдэлийг хугацааны хоцрогдолтойгоор таних зэрэг сул талыг үүсгэж байна. Түүнчлэн санхүүгийн салбар хөгжиж, өсөхийн хэрээр хяналт шалгалтын хамрах хүрээ, зохицуулах аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдэж байгаа ч өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх, өгөгдлийг хуваалцаж, ашиглах зэрэг зайны хяналт, шалгалтын бүхий л шатанд гар ажиллагаа ихээр шаардагдаж байна. Иймд суптекийг ашигласнаар зохицуулагч байгууллагуудын эрсдэлийн удирдлага, хяналт, шалгалтын чадавхыг сайжруулж, боловсон хүчний ажлыг хөнгөвчлөхөөс гадна, байгууллагын үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Суптекийг хэрэгжүүлэхэд техник технологийн шаардлага, тасралтгүй бөгөөд бүрэн өгөгдөл, бат бөх дэд бүтэц шаардагдах тул суптекийг нэвтрүүлэх нь зарим талаараа хүндрэлтэй байж болно. Одоо байгаа зохицуулалтад дасан зохицох, шилжилтийн үе зэргийг удирдах нь бэрхшээл учруулж болзошгүй ба суптекийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь урт хугацаа, хөрөнгө оруулалт шаардсан, нарийн цогц стратегийн үйл ажиллагаа болох юм. Гэсэн хэдий ч суптек нь одоо тулгамдаж буй гол хяналт шалгалтын асуудлуудын шийдэл бөгөөд санхүүгийн системийг тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй байдлаар хөгжих нөхцөлийг бүрдүүлж буй юм. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд суптекийг нэвтрүүлэхийн тулд илүү нарийвчилсан түвшний шинжилгээ, технологийн аудитыг хийж гүйцэтгэн, түүнд үндэслэсэн стратеги төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй юм.

## ЭХ СУРВАЛЖ

- Cambridge SupTech Lab. (2023). State of SupTech Report 2023. University of Cambridge. Available at <https://www.cambridgesuptechlab.org/SOS>
- Crisanto, J. C., Kienecker, K., Prenio, J., & Tan, E. (2023). From data reporting to data-sharing: How far can supotech and other innovations challenge the status quo of regulatory reporting? (FSI Insights on policy implementation No 29). Bank for International Settlements.
- Cambridge Centre for Alternative Finance. (n.d.). SupTech Solutions Tracker. Cambridge SupTech Lab. Available at [https://ccaf.io/suptechlab/solutions\\_tracker/](https://ccaf.io/suptechlab/solutions_tracker/)

## ВИРТУАЛ ХӨРӨНГӨ ГЭЖ ЮУ ВЭ?



**"Виртуал хөрөнгө"** гэж аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэний дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг хэлнэ.

### Виртуал хөрөнгийн давуу болон сул тал

#### Давуу тал:

- Хялбар төлбөр тооцооны хэрэгсэл;
- Хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох;
- Өндөр нууцлалтай;
- Түргэн шуурхай;
- Зардал багатай;
- Цаг хугацаа хэмнэсэн;

#### Сул тал:

- Ханшийн хэлбэлзэл их;
- Террорист этгээдүүдийн санхүүгийн гүйлгээг дамжуулах болон санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх;
- Эх үүсвэр тодорхойгүй өмч хөрөнгийг нуун дарагдуулах;

Хэрэв та виртуал хөрөнгө авах гэж байгаа бол дээрх давуу болон сул тал, мөн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан тавигдах шаардлагуудыг харгалзан үзэж тухайн виртуал хөрөнгийн **WHITE PAPER**-тэй заавал танилцан эрсдэлээ тооцоолон шийдвэрээ гаргаарай.



Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль

**ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР**

## ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН WHITE PAPER /ТАНИЛЦУУЛГА/ ГЭЖ ЮУ ВЭ?

**WHITE PAPER** нь тухайн виртуал хөрөнгийн ирээдүйн эзэмшигчдэд бүтээгдэхүүний онцлог, зорилго, эрсдэлийн талаар мэдээлэл өгөх зорилгоор гаргасан танилцуулга бичиг болно.



### White paper нь дараах агуулгаас бүрдэнэ:



Тухайн виртуал хөрөнгө гаргагчийн танилцуулга;



Хуваарилалт, зарцуулалтын төлөвлөгөө;



Зорилго, алсын хараа;



Технологийн танилцуулга;



Бүтээгдэхүүний танилцуулга;



Эзэмшигчдэд бий болох боломж, үр өгөөж;



Бүтээгдэхүүний онцлог, давуу тал;



Эрсдэлийн талаарх мэдээлэл;



Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

**ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР**

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ-ЫН ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ БУУРУУЛНА ГЭЖ НАЙДАЖ БАЙГАА ЭНЭ ҮЕД АЛТНЫ ҮНЭ ӨСӨХ ХАНДЛАГАТАЙ БАЙГААГ GOLDMAN SACHS –ААС ДАХИН ОНЦЛОВ.**



АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулах дохиог өгч байгаа энэ үед Goldman Sachs-аас алтны үнийн талаарх өөдрөг төсөөллөө дахин гаргалаа. Есдүгээр сарын 16-ны Даваа гарагт Алтны үнэ түүхэн дээд түвшинд хүрч, нэг унц нь 2,589.6 ам.долларт хүрч ам.долларын ханш суларчээ. Есдүгээр сарын 17-18-нд болох Холбооны Нөөцийн банкны хурлаар АНУ-ын бодлогын хүүг 25 нэгжээр бууруулах магадлал 33 хувь, харин 50 нэгжээр бууруулах магадлал 67 хувьтай байна. Мөн Холбооны нөөцийн банк бодлогын хүүг буурах тусам биет алтаар баталгаажсан биржийн арилжааны сангууд тогтмол өсөж байгааг онцолж байна.

*Эх сурвалж: www.reuters.com*

**БЭЭЖИНГИЙН ЭРХ БАРИГЧИД PWC-ИЙН ХЯТАД ДАХЬ САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗУРГААН САРААР ТҮДГЭЛЗҮҮЛЭВ.**

Хятадын зохицуулагч байгууллагын зүгээс үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэгч China Evergrande Group-т хийсэн аудитын шалгалтын улмаас эх газрын Хятад дахь PwC-ийн аудитын нэгжийн үйл ажиллагааг зургаан сараар түдгэлзүүлж, 441 мянган юань буюу 62 мянган ам.долларын торгууль ноогдуулав.

Хятадын зохицуулагч байгууллагаас мэдээлээснээр “PwC-ийн

аудитын нэгж Hengda Real Estate-ийн 2019, 2020 оны жилийн үр дүнд аудит хийж байхдаа Evergrande-ийн луйврыг “нүдээ аниад”, “бүр өршөөсөн” нь тогтоогдсон байна.”



Хятадын Үнэт Цаасны Зохицуулах Хороо (CSRC) мэдэгдэлдээ “PwC нь хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчиж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон” гэж мэдэгджээ. Мөн зохицуулагч байгууллагаас China Evergrande Group-ыг 2020 он хүртэлх хоёр жилийн хугацаанд 78 тэрбум ам.долларын залилан хийсэн гэж буруутгаснаас хойш Хятадын эрх баригчид Evergrande-ийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд PwC-ийн үүрэг оролцоог нарийвчлан судалж байна. PwC нь 2023 оны эхэн үеийг хүртэл 14 жилийн турш Evergrande-д аудит хийсэн байна.

*Эх сурвалж: www.cnn.com*

**ИТАЛИЙН ТӨВ БАНК БУУРАЙ ОРНУУДЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХЭД ТУСЛАХАА МЭДЭГДЭВ.**



Италийн Төв банкны ерөнхийлөгч Фабио Панетта буурай орнуудад нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулахад чиглэсэн төлөвлөгөөг танилцуулж, энэ нь эцсийн дүндээ эрчим хүчний шилжилтийн нийт зардлыг бууруулах боломжтойг мэдэгдэв. Мөн зарим улс орнууд уур амьсгалын асуудлаарх санаачилгын эсрэг "улс төрийн эсэргүүцэлтэй" тулгарснаар тогтвортой хөрөнгө оруулалтын сан руу орох цэвэр урсгал саарч байгааг онцолжээ.

Хөгжиж буй орнууд хямд үнэтэй нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудыг халж, сэргээгдэх эрчим хүчийг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд улам бүр бэрхшээлтэй тулгарч байгаа бөгөөд энэ нь ирэх 11 дүгээр сард Бакуд болох НҮБ-ын цаг уурын асуудлаарх хэлэлцээний хамгийн том маргаантай асуудлууд болсон хэвээр байгаа юм.

Тэрээр Ромд болсон G7-гийн Олон улсын эрчим хүчний ассоциацийн (ОУЭА) бага хурлын үеэр "Эрчимтэй хөгжиж буй зах зээл болон хөгжингүй эдийн засагтай орнуудын шилжилтийн төслүүдийг санхүүжүүлэх нь өндөр хөгжилтэй орнуудынхаас хоёр дахин үнэтэй байх болно" гэж мэдэгдэж байв.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

## ИНДИАНА МУЖИД АММИАКИЙН ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХАД 1.56 ТЭРБУМ ДОЛЛАРЫН НӨХЦӨЛТЭЙ ЗЭЭЛ САНАЛ БОЛГОВ.



АНУ-ын Эрчим хүчний яамнаас Индиана мужид утаа багатай аммиакийн үйлдвэр барихад туслах зорилгоор Wabash Valley Resources компанид 1.56 тэрбум ам.долларын нөхцөлтэй зээлийн баталгаа гаргажээ. Төслийн хүрээнд газрын тос боловсруулах явцад үүссэн хаягдал петкогыг ашиглан жил бүр 500,000 тонн аммиак үйлдвэрлэж, нүүрсхүчлийн хийг

газар доор байнга хадгалдаг цахилгаан станцыг шинэчлэх зорилготой.

Бордоо үйлдвэрлэхэд өргөн хэрэглэгддэг аммиакийн үйлдвэрлэл нь дэлхийн нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлын 1-2 хувийг бүрдүүлдэг. АНУ-ын хөдөө аж ахуйн салбарын шууд ялгаруулалт нь АНУ-ын нийт ялгарлын бараг 10%-ийг бүрдүүлдэг байна. АНУ-ын Эрчим хүчний яамнаас "Энэхүү төсөл нь АНУ-ын баруун мужуудын эрдэнэ шишийн бүс нутгийн тариаланчдад зориулсан нүүрстөрөгчийн давхар ислийг бага ялгаруулдаг аммиакийг дотооддоо үйлдвэрлэх анхны төсөл болно." гэж мэдээлэв.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

## ALIBABA КОМПАНИЙН ТАОВАО ХУДАЛДААНЫ АППЛИКЕЙШН СИНГАПУРТ ХИЙМЭЛ ОЮУН УХААНААР (AI) АЖИЛЛАДАГ АНГЛИ ХУВИЛБАРЫГ ГАРГАЛАА.



Таобао худалдааны аппликейшн нь хиймэл оюун ухаанаар ажилладаг англи хувилбарыг гаргаж Сингапурын App Store-ийн жагсаалтыг тэргүүлснээс гадна Хятад улсаас бусад улсын хэрэглэгчдийн хүртээмжийг нэмэгдүүлсэн томоохон шинэчлэлт боллоо.


Таобао зүгээс энэхүү шинэчлэлтээ Сингапур, Малайзын зах зээлд хамгийн түрүүнд санал болгож буй бөгөөд хиймэл оюун ухааныг ашиглан орчуулга хийх нь худалдан авалтыг хялбаршуулж байгаа ч орчуулгын алдаа, мөнгөн тэмдэгтийг харуулах зэрэг зарим дутагдалтай талууд байсаар байна.

Алибаба дэлхий даяар өргөжин тэлсээр байгаа бөгөөд барууны зах зээлд гарахын тулд Сингапурыг туршилтын талбар болгон ашиглаж байгаа нь Хятадын компаниуд бүс нутгийн томоохон зах зээлийг ашиглах хандлагатай байгааг харуулж байна.

Эх сурвалж: [www.cnbc.com](http://www.cnbc.com)

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

